



## **МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ СПОРТЫН АРБИТР**

[www.sportarbitration.mn](http://www.sportarbitration.mn)



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ  
СПОРТЫН АРБИТР



# Спортын арбитрын шийдвэр гаргах, шийдвэрийн хүчин төгөлдөр байдал



## **Спортын арбитрын шийдвэр гаргах эрх зүйн сурвалж**

1 . Олон улсын спортын арбитрын шүүхийн дүрэм /2023.02.23.ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдсөн Швейцарь улс, Женев хот/

а/ Спортын маргаан шийдвэрлэх эрх бүхий байгууллагуудын дүрэм хамтарсан шийдвэр

б/ Энэхүү дүрэмд “Хэрэг хянан шийдвэрлэх дүрэм”- ийн R59 үндсэн шийдвэр гаргах үүнийг жишиг болгох

2 . МУ-ын Иргэний хуулийн 9 дугаар зүйлийн 9.3-д “ Иргэний эрх зүйн хамгаалалтыг

шүүх, арбитр хуулиар тогтоосон журам, аргаар хэрэгжүүлнэ.” гэж хуульчилсан



3 . МУ-ын “Арбитрын тухай хууль,-ийн “Зургаадугар бүлэг  
“ 42 дугаар зүйлд Арбитрын бүрэлдэхүүн шийдвэр гаргахаар  
хуульчлан зохицуулсан./2017/

4 . “Спортын арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрэм” – ийн  
36 дугаар зүйлээр зохицуулсан. Удирдах Зөвлөлийн 2023.11.29-  
ны өдрийн 23/21 тогтоолын 1-р хавсралтаар баталж, 2023.12.1-  
ээс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн.



## *Спортын арбитрын шийдвэрийн төрөл*

Спортын арбитрын шийдвэр нь 2 төрөлтэй байна . Үүнд :

а/ Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны явцын, б/ Үндсэн шийдвэр гэсэн :

Маргааны хянан шийдвэрлэх ажиллагааны явцын шийдвэрүүд :

А / Спортын арбитрын дүрмийн 24 дүгээр зүйлд “ Арбитрын ажиллагааны явуулах журмыг тодорхойлох “ шийдвэр

Б / Маргаанд гуравдагч этгээд оролцуулахаар талуудаас болон сонирхогч этгээдийн гаргасан хүсэлтийг шийдвэрлэх /28 дугаар зүйл/

В / Маргаан хянан шийдвэрлэх явцад хэргийн бодит байдлыг тогтооход зайлшгүй ач холбогдол бүхий шинжээчийн дүгнэлт, үзлэг, туршилт гэх мэт нөхцөлийг тогтооход гаргах шийдвэр : / 29,30 дугаар зүйлүүд /

Г / Спортын арбитрын Үндсэн шийдвэр



*Спортын арбитрын шийдвэрүүд гаргах эрх зүйн хэм хэмжээ*

- 1 . “Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны явцын шийдвэрт “ процессын “
- 2 . Спортын арбитрын “Үндсэн шийдвэрт “ материаллаг “ хэм хэмжээг хэрэглэнэ.

*Маргааны явцын ба үндсэн шийдвэрийн бүтэц :*

- 1 . Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны явцын шийдвэр нь :
    - а / “Заавал гаргах “ Арбитрын ажиллагаа явуулах журам тодорхойлох” шийдвэр
- Үүнд :
- 1 . Арбитрын бүрэлдэхүүнийг татгалзах оролцогчидын хүсэлт байгаа эсэх
  - 2 . Спортын арбитрт гаргасан нэхэмжлэл нь арбитрын харьяалалтай эсэх
  - 3 . Бусад нь дүрмийн 24,25,26, 27,33 дугаар зүйлд заасан асуудлуудыг оролцогчидын саналыг харгалзан арбитрын бүрэлдэхүүний хамтын тохиролцоотойгоор арбитрын бүрэлдэхүүн шийдвэрлэж , шийдвэрт оролцогчид болон арбитрын бүрэлдэхүүн гарын үсэг зурна.



4 . Энэхүү шийдвэрт оролцогчид гомдол гаргах эрхгүй байна.

б / Үндсэн шийдвэр нь :

1 . Удиртгал

2 .Тодорхойлох

3 . Шийдвэрлэх /үндэслэх/

4 . Шийдвэрлэсэн нь гэсэн хэсгээс бүрдэнэ.



Шийдвэрийн хүчин төгөлдөр байдал :

1 . Спортын арбитрын шийдвэр хүчин төгөлдөр байх үндэслэлүүд :

Үүнд : Олон Улсын ба үндэсний арбитрын шийдвэр нь Үндэсний ба дотоодын гэсэн ангилалтай байдаг .

**А / Үндэсний арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх эрх зүйн зохицуулалт :**

- Монгол Улсын Үндсэн хууль 10 дугаар зүйлийн 2
- ИХШХШ тухай хууль – ийн 184 дүгээр зүйл
- Арбитрын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т заасан үндэслэлээс бусад тохиолдолд арбитрын шийдвэр хүчин төгөлдөр хэвээр байна .
- “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”ийн 166.1-д заасны дагуу гүйцэтгэх баримт бичгийн дагуу арбитрын шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй гүйцэтгэх ажиллагаа хийнэ.
- “Спортын арбитрын хэрэг шийдвэрлэх дүрэм”-ийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2 –т зааснаар зохицуулагдана.



### ***Б / Гадаадын арбитрын хувьд :***

- Хүлээн зөвшөөрч баталгаажуулсан эсэх /Recognition/ Хэрэв хүлээн зөвшөөрсөн бол гүйцэтгэх /Enforcement/ ажиллагаа дотоодынхтой адил зохицуулалттай.
- 1958 оны Нью-Йоркийн конвенцийн 3 дугаар зүйлд “хэлэлцэн тохирогч улс бүр арбитрын шийдвэрийг заавал биелүүлэх шийдвэр гэж хүлээн зөвшөөрөх бөгөөд түүнийг өөрийн улсын хэрэг шийдвэрлэх эрхийн хэм хэмжээнг баримтлан ... шийдвэрлэнэ “гэж заасан нь :
  - 1 . Заавал хүлээн зөвшөөрөх, биелүүлэх үүрэгтэй
  - 2 . Хэрхэн, яаж хэрэгжүүлэх нь эрх зүйн тогтолцоо, соёл, уламжлал уламжлалын онцлог байдлуудтай холбоотой, нээлттэй зохицуулалт
  - 3 . Зөвхөн шүүхээр баталгаажуулсан албан ёсны шийдвэр гарч, түүнд үндэслэн гүйцэтгэх хуудас олгогдсон байх нь тухайн шийдвэр биелүүлэх үндсэн шаардлага болж байна.



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ  
СПОРТЫН АРБИТР



# АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА